



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/447

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", "л" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сарлаг өсгөх" төслийн хүрээнд гэрээ байгуулах болон санхүүжилтийг шийдвэрлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд: Г.Бат-Өлзий –Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Пүрэвсүрэн- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Сарлаг өсгөх төслийн хүрээнд дэмжигдсэн хоршооны үйл ажиллагаа, чадамжийг илтгэх, үе шатны ажлын хуваарь, үнийн санал зэргийг харгалзан үзэж гэрээ байгуулах эсэх асуудлаар дүгнэлт гаргахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Сарлаг өсгөх төслийн ажлын гэрээг хуулийн дагуу зохион байгуулж, Засаг даргад тайлагнан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн /Б.Түмэндэмбэрэл/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/447 Ch
02 01983